



**ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/145

Зуунмод

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.8 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны “Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг эхлүүлэх тухай” А/273 дугаар захирамж, Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2023 оны “Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 12-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

2. Багийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

2.1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд малчин, мал бүхий иргэдийг идэвхтэй оролцуулж үхэр, гахай сүргийг толгой дараалан бүрэн хамруулах ажлыг багийн хэмжээнд чанартай зохион байгуулах.

2.2. Вакцин хийгдэх малчин мал бүхий өрхийн нутаглаж байгаа газар, гэрийн хаяг, холбоо барих утасны дугаар, малын тоо толгойг төрөл тус бүрээр үнэн зөв гаргаж, товлосон газар, хугацаанд мал сүргийг цуглуулж, малын эмч нарын ажиллах нөхцөл боломжоор хангаж өгөх бэлтгэх.

3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (Г. Цэндсүрэн)-д ДААЛГАХ нь:

3.1. Малд эрүүл мэндийн үзлэг хийж, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг заасан хугацаанд, стандарт, зааврын дагуу хийж, гүйцэтгэлийг мал эмнэлгийн нэгдсэн цахим системд төлөвлөгөөний дагуу газар дээрээс нь оруулж бүртгэх.

3.2. Мал эмнэлгийн нэгдсэн системд гүйцэтгэлийг оруулахдаа тухайн айл өрхийн мал их бага хэмжээгээр А данснаасаа зөрсөн тохиолдолд заавал тайлбар хэсэгт оруулж тарьсан вакцины серийн дугаар бүхий зургийг хавсарган, тун, хэмжээ хэсэгт тоо, мл-ээр нэг бүрчлэн тайлагнах.

3.3.Тарилга хийсэн тухай акт, бусад шаардлагатай баримтыг газар дээр нь үнэн зөв үйлдэж холбогдох хүмүүсээр гарын үсэг зуруулж малчны тэмдгийг дарж баталгаажуулах.

3.4.Вакцины хадгалалтын горим алдагдах, хорогдол гаргахаас зайлс хийж, нэг өдөрт тарих малын тоо, зарцуулах вакцины хэмжээг тухай бүр нарийн тооцож, явцын мэдээг Мал эмнэлгийн тасагт мэдээлэх.

3.5.Малчдад дархлаажуулалтын арга хэмжээний талаар зохих мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж, гарын авлага өгөх, малын эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэл хийн баталгаажуулах.

3.6.Тарилга хийсэн тухай материалыг журмын дагуу бүрдүүлж, Мал эмнэлгийн газарт ирүүлэх 2023 оны 05 дугаар сарын 15-ны дотор багтаан ирүүлэх

4.Малчин бүхий иргэдэд ДААЛГАХ нь:

4.1.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад үхэр, гахай сүргийг бүрэн хамруулж, малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийлгэн, вакцин тариулсан тухай баталгаажуулалт гаргаж өгөх.

4.2.Мал сүргээ бөөнд нь хашиж тариулах хашаа хороог засаж бэлдэх, товлосон газарт бэлэн байлгаж, тарилга хийхэд хүн хүчээр тусалж, малаа бүрэн хамруулах.

4.3.Мал сүргийг байнгын хариулга маллагаатай байлгаж, ажиглан, өвчний шинж тэмдэг илэрсэн үед хариуцсан малын эмч, багийн Засаг дарга, сумын мал эмнэлгийн тасагт яаралтай мэдэгдэх.

4.4.Малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийн ажлыг багийн Засаг дарга болон малын эмчид мэдэгдэн зөвшөөрөлгүй хийхгүй байх.

5.Вакцинжуулалтын ажлыг стандартын дагуу богино хугацаанд үр дүнтэй, шуурхай зохион байгуулж ажиллахыг тархвар зүйч (Э.Долгормаа)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.САРАНГЭРЭЛ

